

Дархан-Уул аймгийн Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын 2024 оны 11 дүгээр сарын 25-т албан бичгийн хавсралт



“ДЭЛХИЙН ХҮҮХДИЙН ӨДӨР”-ИЙГ ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛСЭН ТУХАЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2024.11.25

Дархан-Уул аймаг

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, МУ-ын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, МУ-ын Засгийн газар-НҮБ-ын Хүүхдийн сангийн 2023-2027 оны хамтарсан хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2024-2025 оны Мэдээлэл харилцааны хамтын ажиллагааны төлөвлөгөөг тус тус үндэслэн улсын хэмжээнд зохион байгуулагдаж байгаа тус аянд Дархан-Уул аймгийн Соёл, урлагийн байгууллагууд нэгдэн ажиллалаа. **Үүнд:**

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газрын 2024 оны 11 дүгээр сарын 15-ны 01/586 тоот албан бичгийн дагуу тус газар нь “Дэлхийн хүүхдийн өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх тухай чиглэлийг харьяа 7 байгууллагад хүргүүлж тайланг 2024 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр холбогдох газарт хүргүүлэхээр бэлтгэлээ. “Нэгдүгээрт хүүхэд”, “Ирээдүйгээ сонсьё” уриан дор зохион байгуулагдаж буй аян нь “Дэлхийн хүүхдийн өдөр”-ийн тухай мэдлэг ойлголтыг сурталчлан таниулах, хүүхдийн танин мэдэхүйг сайжруулах, авьяас чадварыг дэмжих, үзэл бодол дуу хоолойг нь сонсох, хүүхдийн нас сэтгэхүйн онцлогт тохирсон арга хэмжээг зохион байгуулж оюуны хөрөнгө оруулалт, гэгээлэг дурсамжийг үлдээх зорилготой юм.

Дархан-Уул аймгийн Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар:

1. НҮБ-ын Хүүхдийн сангийн дэлхийн хүүхдийн өдөрт зориулсан контент, зар сурталчилгааг өөрсдийн нийгмийн сүлжээнд байршуулж тус аянд зориулж постер бэлтгэж харьяа байгууллага болон төр, хувийн хэвшлийн байгууллагуудыг уриалсан.



2. Байгууллагын Эцэг эхийн зөвлөлөөс 2024.11.21-ний өдөр аймгийн хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газраас хүүхэд, гэр бүлд ээлтэй байх дүрэм журмыг сайжруулах талаар сургалт, зөвлөгөөг авч тус сэвдийн хүрээнд дотоод яриаг өрнүүлэн, байгууллага хамт олноороо цэнхэр өнгийн хувцсаар ижилсэн, цахим сувгаа цэнхэртүүлсэн.



3. 2024.11.18-ны өдөр аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газрын хүүхдийн улсын байцаагч тус газарт ажиллаж Хүүхэд хамгааллын бодлогыг хэрхэн хэрэгжүүлсэн талаарх баримт бичгүүдтэй танилцаж зөвлөмж өглөө.




4. 2024.11.20-ны өдөр байгууллагын эцэг эхийн зөвлөлөөс байгууллагын албан хаагчдын хүүхдүүдийг ажлын байран дээр хүлээн авч эцэг эхийн ажлын байртай танилцуулах арга хэмжээг зохион байгууллаа.



Дархан-Уул аймгийн Төв номын сан:

Соёл, урлаг, аялал жуулчлал, Залуучуудын газраас “Дэлхийн номын өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх тухай чиглэлийн дагуу 2024.11.20-ны өдөр байгууллагын эцэг эхийн зөвлөлөөс хүүхдүүдэд өөрсдөд нь тулгамсан асуудлаар томчуудад дуу хоолойгоо өргөж, хүүхдийн эрх чөлөө, үзэл бодлыг нь сонсох, хүүхдийн нас сэтгэхүйн онцлогт тохирсон арга хэмжээг зохион байгуулж оюуны хөрөнгө оруулалт, гэгээлэг дурсамжийг үлдээх зорилготойгоор дараах арга хэмжээг зохион байгуулж ажиллалаа. Үүнд:

1. Тус аяны тохиолдуулан тус байгууллагаас мэндчилгээ бэлтгэн цахим хуудсанд байршуулж олон нийтэд сурталчиллаа.



2. Тус номын сан нь 16 ажилтан албан хаагчийн нийт 38 хүүхэдтэй бөгөөд Насанд хүрсэн болон 4-өөс доош насны 28 хүүхэд хасагдаж, 10 хүүхдийг байгууллага дээрээ хүлээн авч уулзалт өдөрлөгийг зохион байгуулсан.



- “Ирээдүйгээ сонсъё” уриатайгаар зохион байгуулгаждаг буй тус өдөрлөгт Төв номын сангийн хамт олон [цэнхэр өнгийн хувцас](#), [цэнхэр энгэрийн зүүлтээр ижилсэж](#), хүүхдүүдээ ажлын байрандаа урин тэдний дуу хоолойг сонсохоор хүлээн авч уулзлаа.


Уулзалтыг зохион байгуулалттайгаар төлөвлөгөө гарган баттуулж, хөтөлбөрийн дагуу явуулсан бөгөөд хөтөлбөрт ажилтан албан хаагчдын хүүхдүүд аав, ээжийнхээ ажилтай танилцаж сонирхолтой, дурсамж дүүрэн аяллыг бүтээхээр тусгав.



/Тус өдөр эцэг эх, асран амгаалагчдын хамт Музей болон Эмэгтэйчүүдийн ордны үйл ажиллагаатай танилцан, уран зураг үзэж сонирхов/



/Канвас зургийн гайхамшигийг мэдрэн өөрсдийн дуртай зургаа урлаж дурсгалын бэлэг болгон авав/



Дархан-Уул аймгийн Хүүхдийн номын ордон:

2024.11.20-нд "Дэлхийн хүүхдийн өдөр"-ийг тохиолдуулан Хүүхдийн номын ордны нийт уншигч хүүхдүүддээ зориулж "**Ирээдүйгээ сонсъя**" уриан дор 5 төрлийн үйл ажиллагааг зохион байгуулж ажиллалаа. Үүнд:

1. Уламжлалт тоглоом болох шагай наадгай, Эв долоо, Хорол тоглоом, Оюуны хөзөр, Шатар, даам, Англи цагаан толгойн үсэг эвлүүлэх, уг бүтээх, Ном унших цаг зэрэг 8 төрлийн тоглоом наадгайг танилцуулж олон сонирхолтой хөтөлбөрүүдтэй явагдаж нийт 155 гаруй хүүхдийг хамруулан зохион байгуулав.



2. Энэ өдөр цахимаар Дэлхийн хүүхдийн өдөртэй холбоотой **6** мэдээлэл мөн 3 контент, 3 зурган мэдээлэл байгууллагын пэйж хуудсаар олон нийтэд түгээсэн. Цахим хандалт- **3695**



3. “Ирээдүйгээ сонсъё” уриан дор зохион байгуулгажд буй “Дэлхийн хүүхдийн өдөр”-өөр томчууд бид хүүдийн төлөө дуу хоопойгоо нэгтгэн, тэдний үзэл бодлыг сонсох, хүүхдийн нас сэтгэхүйн онцлогт тохирсон арга хэмжээг зохион байгуулж оюуны хөрөнгө оруулалт, гэгээлэг дурсамжийг үлдээх зорилгоор уриалга контент видео бичлэгийг бэлтгэж олон нийтэд суратлчилсан.



4. Монголын Оюуны Тэрбум Клубын чиглүүлэгч, өв тээгч, өвлөн уламжлагч С.Оюунгэрэл багш маань тус ордонд хүрэлцэн ирж “Хүлэг баатрын шүлэг”-ээс уншигч хүүхдүүдэд маань танин мэдүүлж оюуны цангааг тайлж үнэ цэнэтэй сургалтыг зохион байгуулав.



5. Тус аянг утган байгууллагын орчинг цэнхэр өнгөөр тохижуулж байгууллагын хамт олон цэнхэр өнгийн хувцсаар ижилссэн юм.



Орхон сумын соёлын төв:

2024.11.20-нд "Дэлхийн хүүхдийн өдөр"-ийг тохиолдуулан Орхон сумын соёлын төв сумын хүүхэд залуучуудад зориулж "Ирээдүйгээ сонсъя" уриан дор 4 арга хэмжээг зохион байгуулж ажиллалаа. Үүнд:

1. "Дэлхийн хүүхдийн өдөр"-ийг утган сумын ЕБ-ийн 8 дугаар сургуулийн 9 дүгээр ангийн 150 гаруй сурагчдад тус өдрийн талаар мэдээлэл хүргэж дэлхийн бусад орнууд хэрхэн тэмдэглэдэг, анх хэзэнээс эхлэн тэмдэглэж ирсэн, хачнээн оронд тэмдэглэж хүүхдийн эв нэгдлийг бэхжүүлэх, тэдний асуудалд анхаарлаа хандуулж ажилладаг талаар мэдээлэл өглөө.




2. Дэлхийн хүүхдийн өдрийг тохиолдуулан БНУ-ыг тунхаглаж, анхдугаар үндсэн хууль батлагдсаны түүхт 100 жилийн ойн холбогдолтой монголын түүх болон хүүхдийн эрхийн талаар танин мэдэхүйн асуулт бэлтгэн АХА тэмцээн зохион байгуулав.



3. “Ирээдүйгээ сонсьё” уриатай тус өдрөөр цэнхэр гэрэл асааж хүүхэд багачуудаа хүндэтгэн тэдний төлөө ЗА гэж хэлж эрхийг нь дээдэлж Нэгдүгээрт хүүхэд гэсэн уриалгыг хэрэгжүүлэн ажиллалаа.



4. Тус өдрийн хүрээнд сумын хүүхэд залуучуудын дунд “Салхинд гарья” аялалыг зохион байгуулав. Хүүхдүүдийн дуу хоолой, тэдний үзэл бодлыг сонсох таатай цагийг өнгөрөөсөн юм. Энэ үеэр хүүхэд бүр аз жаргалтай байх уриаг нэгэн дуу хоолойгоор илэрхийлсэн юм.



Шарын гол сумын соёлын төв:

Жил бүрийн 2024.11.20-ны өдөр “Дэлхийн хүүхдийн өдөр” тохиодог. Тус өдрөөр шарын гол сумын соёлын төв сумын хүүхэд залуучуудад зориулж **“Ирээдүйгээ сонсья”** уриан дор 3 арга хэмжээг зохион байгуулж ажиллалаа. Үүнд:

1. Шарын гол сумынхаа ЕБС-н 2 болон 6-р сургуулийн үүдний танхимд “Ирээдүйгээ сонсъя” уриатай ирээдүй хойч үе болсон хүүхдүүдийнхээ дуу хоолойг сонсох, үг дайх хайрцгийг байршууллаа.



2. Тус сумын пэйж хуудсаар “Дэлхийн хүүхдийн өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх тухай мэндчилгээг дэвшиүүлж коверыг “Ирээдүйгээ сонсъё” уриатай зурагт хуудсаар сольж байршууллаа.




3. Дэлхийн хүүхдийн өдрийг тохиолдуулан Шарын гол Соёлын төв -н удирдлага ажилтан, албан хаагчдынхаа хүүхдүүдийг хүлээн авч, уулзалт ярилцлага өрнүүлж, санаа бодлыг сонсож, ажил мэргэжлээ танилцууллаа.




Дархан-Уул аймгийн Музей:

Жил бүрийн 2024.11.20-ны өдөр “Дэлхийн хүүхдийн өдөр” тохиодог. Тус өдрөөр аймгийн Музей нь хүүхэд багачуудад зориулж “Ирээдүйгээ сонсъя” уриан дор 2 арга хэмжээг зохион байгуулж ажиллалаа. Үүнд:

1. Хүүхдийн Эрхийн тухай Конвенц батлагдсан энэ өдрийг Дэлхийн хүүхдийн Эрхийн өдөр хэмээн улс орнууд тэмдэглэдэг. Энэ өдөр дэлхий даяар эв нэгдлийг сурталчлах, дэлхийн өнцөг булан бүрт амьдарч буй хүүхдүүдэд тулгардаг бэрхшээлийг ойлгож ухамсарлах, бүх хүүхдийн сайн сайханд хувь нэмэр оруулах өдөр юм. Энэ зорилгын хүрээнд өнөөдөр Дархан-Уул аймгийн Музей нь бага наасны хүүхдүүдэд соёлын боловсролын хөтөлбөрийг амжилттай зохион байгуулан ажиллалаа.



2. НҮБ-ын Хүүхдийн сан, аймгийн Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газраас дэлхийн хүүхдийн өдөрт зориулсан контент, зар сурталчилгааг өөрсдийн нийгмийн сүлжээнд байршуулж тус аянд зориулж постер бэлтгэн нэгдлээ.



ТАЙЛАН БИЧСЭН:

СОЁЛ, УРЛАГ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН ГАЗРЫН
АРХИВ-БИЧИГ, ХЭРЭГ, НЯРАВ

Г.Чодоглас Г.УНДАРМАА